



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/008/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Т.Батсүх
Утас: 70453799, Цахим хаяг: Batsukht@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн
 - 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНТҮГ-ЫН
ЗАХИРАЛ З.БАЛЖИННЯМ
ТАНАА

2026.03.13 № УВА-2026/008/НА-СТА-ОНТҮГ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаангом тохижилт үйлчилгээ”-ОНТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Улаангом тохижилт үйлчилгээ”-ОНТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

8525050735

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М. БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан/

төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>169,422,410.11</u>	<u>266,223,139.64</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,584,538.89	41,120.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,584,538.89	41,120.49
3121	Төгрөг	4,584,538.89	41,120.49
31213	Арилжааны банк дахь харилцах	4,584,538.89	41,120.49
33	АВЛАГА	211,821.22	12,656,972.15
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	211,821.22	1,176,972.15
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	11,480,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	164,626,050.00	253,525,047.00
351	Түүхий эд материал	514,800.00	0.00
35110	Тусгай зориулалттай материал	514,800.00	0.00
354	Хангамжийн материал	164,111,250.00	253,525,047.00
35420	Аж ахуйн материал	6,098,000.00	5,800,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	6,700,000.00
35470	Бусад хангамжийн материал	158,013,250.00	241,025,047.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,456,983,883.71</u>	<u>26,493,396,554.45</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,456,983,883.71	26,493,396,554.45
392	Биет хөрөнгө	3,329,744,883.71	24,366,223,554.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,691,573,345.01	4,729,777,671.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,194,842,935.09	-1,214,334,606.81
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,298,608,659.00	1,996,010,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-603,376,977.78	-731,390,908.25
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,073,500.00	35,404,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,081,366.66	-13,607,499.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,419,614.42	19,687,064.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,407,721.85	-5,912,201.23
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,717,452,192.00	26,325,362,654.27
39215	Хуримтлагдсан элэгдэл	-618,099,504.34	-6,803,199,198.52
39216	Дуусаагүй барилга, байгууламж	28,426,079.00	28,426,079.00
393	Биет бус хөрөнгө	2,127,239,000.00	2,127,173,000.00
39301	Программ хангамж	1,100,000.00	1,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-605,000.00	-671,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,126,744,000.00	2,126,744,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,626,406,293.82</u>	<u>26,759,619,694.09</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>729,387.32</u>	<u>38,328,756.95</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	729,387.32	38,328,756.95
413	Өглөг	729,387.32	38,328,756.95
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	729,387.32	8,128,756.67
4136	Бусад өглөг	00.00	30,200,000.28
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	30,200,000.28
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,625,676,906.50</u>	<u>26,721,290,937.14</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,625,676,906.50	26,721,290,937.14

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	15,535,478,635.36	15,535,478,635.36
51101	Өмч: - төрийн	15,535,478,635.36	15,535,478,635.36
512	Хуримтлагдсан үр дүн	-10,055,425,042.10	11,040,213,852.54
51210	Өмнөх үеийн үр дүн	-10,055,425,042.10	-10,055,400,178.10
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	21,095,614,030.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	145,623,313.24	145,598,449.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,626,406,293.82	26,759,619,694.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,145,399,973.74	24,714,399,676.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	779,579,273.74	22,560,829,876.26
120	Нийтлэг татварын бус орлого	779,579,273.74	22,560,829,876.26
120002	Хүүгийн орлого	182,887.74	199,480.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,315,000.00	653,288,309.37
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,909,000.00	245,452,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,406,000.00	407,835,909.37
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	727,081,386.00	21,858,672,626.73
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	0.00	48,669,460.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,365,820,700.00	2,153,569,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,365,820,700.00	2,153,569,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,365,820,700.00	2,153,569,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,106,314,440.60	3,618,301,250.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,106,314,440.60	3,618,301,250.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,056,964,998.00	3,558,643,050.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	796,531,420.27	1,317,649,282.00
210101	Үндсэн цалин	796,531,420.27	1,317,649,282.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,565,496.96	171,988,120.67
210201	Тэтгэврийн даатгал	102,565,496.96	171,988,120.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	154,406,962.09	180,683,825.58
210301	Гэрэл, цахилгаан	135,553,433.59	147,037,045.58
210302	Түлш, халаалт	16,494,387.50	15,628,800.00
210303	Цэвэр, бохир ус	2,359,141.00	18,017,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	198,965,363.00	265,495,587.00
210401	Бичиг хэрэг	1,798,180.00	6,643,905.00
210402	Тээвэр, шатахуун	189,328,994.00	252,698,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,852,989.00	1,774,132.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,760,200.00	3,894,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,225,000.00	484,600.00
2105	Нормативт зардал	10,625,000.00	19,848,700.00
210502	Хоол, хүнс	00.00	2,838,700.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,625,000.00	17,010,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,528,260.00	224,495,890.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	300,000.00
210604	Урсгал засвар	85,528,260.00	224,195,890.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	3,570,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	3,570,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,882,030.78	472,877,284.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,040,917.34	462,519,585.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,200,000.00	4,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,009,875.00	1,636,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	597,796.00	1,223,683.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	275,500.00	187,000.00
210807	Газрын төлбөр	2,631,006.00	3,110,816.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	126,936.44	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	689,460,464.90	902,034,360.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	450,000.00	70,626,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	689,010,464.90	831,407,860.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,349,442.60	59,658,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,349,442.60	59,658,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,241,000.00	2,250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,254,440.00	51,608,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,854,002.60	5,800,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	39,085,533.14	21,096,098,426.02
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	484,395.38
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	484,395.38
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-484,395.38
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	39,085,533.14	21,095,614,030.64

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,418,708,587.74	2,795,577,589.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,887,887.74	642,007,789.53
120	Нийтлэг татварын бус орлого	52,887,887.74	642,007,789.53
120002	Хүүгийн орлого	182,887.74	199,480.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,705,000.00	641,808,309.37
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,249,000.00	233,972,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,456,000.00	407,835,909.37
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,365,820,700.00	2,153,569,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,365,820,700.00	2,153,569,800.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,365,820,700.00	2,153,569,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,409,085,479.00</u>	<u>2,790,488,707.93</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,409,085,479.00	2,790,488,707.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,358,965,145.00	2,727,370,507.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	796,962,825.37	1,311,974,638.25
210101	Үндсэн цалин	796,962,825.37	1,311,974,638.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,730,863.76	171,228,546.00
210201	Тэтгэврийн даатгал	98,730,863.76	171,228,546.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	154,406,962.09	150,623,825.30
210301	Гэрэл, цахилгаан	135,553,433.59	116,977,045.30
210302	Түлш, халаалт	16,494,387.50	15,628,800.00
210303	Цэвэр, бохир ус	2,359,141.00	18,017,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	198,395,528.00	265,863,503.00
210401	Бичиг хэрэг	1,824,580.00	6,158,405.00
210402	Тээвэр, шатахуун	189,302,594.00	252,622,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,432,954.00	1,943,132.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	3,970,000.00	3,380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,865,400.00	1,759,816.00
2105	Нормативт зардал	10,995,000.00	20,673,700.00
210502	Хоол, хүнс	00.00	2,838,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,995,000.00	17,835,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,744,900.00	173,090,511.00
210601	Багаж техник хэрэгсэл	200,000.00	0.00
210604	Урсгал засвар	74,544,900.00	173,090,511.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	3,570,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	3,570,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,279,065.78	482,307,284.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,456,442.93	471,949,585.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,200,000.00	4,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	1,636,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	682,446.00	1,223,683.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	275,500.00	187,000.00
210807	Газрын төлбөр	2,549,556.00	3,110,816.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	115,120.85	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	450,000.00	148,038,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	450,000.00	148,038,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,120,334.00	63,118,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,120,334.00	63,118,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,736,894.00	2,250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,254,440.00	51,608,200.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,129,000.00	9,260,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>9,623,108.74</u>	<u>5,088,881.60</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	34,674,709.00	9,632,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,674,709.00	9,632,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34,674,709.00	9,632,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,674,709.00	9,632,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-34,674,709.00</u>	<u>-9,632,300.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-25,051,600.26	-4,543,418.40
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,636,139.15	4,584,538.89
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,584,538.89	41,120.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	15,535,478,635.36	145,623,313.24	-10,083,617,227.69	5,597,484,720.91
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,535,478,635.36	145,623,313.24	-10,083,617,227.69	5,597,484,720.91
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-10,893,347.55	-10,893,347.55
C08	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	15,535,478,635.36	145,623,313.24	-10,055,425,042.10	5,625,676,906.50
D01	2025 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	15,535,478,635.36	145,623,313.24	-10,055,425,042.10	5,625,676,906.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	24,864.00	24,864.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,535,478,635.36	145,623,313.24	-10,055,400,178.10	5,625,701,770.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-24,864.00	00.00	-24,864.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	21,095,614,030.64	21,095,614,030.64
D09	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	15,535,478,635.36	145,598,449.24	11,040,213,852.54	26,721,290,937.14

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,800,121,007.93	2,800,121,007.93	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,800,121,007.93	2,800,121,007.93	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,737,002,807.93	2,737,002,807.93	0.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,311,974,638.25	1,311,974,638.25	0.00
210101	Үндсэн цалин	1,311,974,638.25	1,311,974,638.25	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	171,228,546.00	171,228,546.00	0.00
210201	Тэтгэврийн даатгал	171,228,546.00	171,228,546.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150,623,825.30	150,623,825.30	0.00
210301	Гэрэл, цахилгаан	116,977,045.30	116,977,045.30	0.00
210302	Түлш, халаалт	15,628,800.00	15,628,800.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	18,017,980.00	18,017,980.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	266,113,503.00	266,113,503.00	0.00
210401	Бичиг хэрэг	6,408,405.00	6,408,405.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	252,622,150.00	252,622,150.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,943,132.00	1,943,132.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,380,000.00	3,380,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,759,816.00	1,759,816.00	0.00
2105	Нормативт зардал	20,673,700.00	20,673,700.00	0.00
210502	Хоол, хүнс	2,838,700.00	2,838,700.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,835,000.00	17,835,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	182,472,811.00	182,472,811.00	0.00
210602	Тавилга	9,382,300.00	9,382,300.00	0.00
210604	Урсгал засвар	173,090,511.00	173,090,511.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	3,570,000.00	3,570,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	3,570,000.00	3,570,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	482,307,284.38	482,307,284.38	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	471,949,585.38	471,949,585.38	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,200,000.00	4,200,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,636,200.00	1,636,200.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,223,683.00	1,223,683.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	187,000.00	187,000.00	0.00
210807	Газрын төлбөр	3,110,816.00	3,110,816.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	148,038,500.00	148,038,500.00	0.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	148,038,500.00	148,038,500.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,118,200.00	63,118,200.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,118,200.00	63,118,200.00	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,250,000.00	2,250,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,608,200.00	51,608,200.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,260,000.00	9,260,000.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,795,378,109.37	2,795,378,109.37	0.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,153,569,800.00	2,153,569,800.00	0.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,153,569,800.00	2,153,569,800.00	0.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	641,808,309.37	641,808,309.37	0.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	233,972,400.00	233,972,400.00	0.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	407,835,909.37	407,835,909.37	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,584,538.89	4,584,538.89	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	41,120.49	41,120.49	0.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	56.00	56.00	0.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	44.00	44.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ОНТҮГ, түүний үйл ажиллагаа

Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ нь Төрийн үйлчилгээний байгууллагын манлайллыг дээшлүүлж, аймаг сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, зохион байгуулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж цэвэр орчинд ая тохитой амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Стратеги зорилтууд:

SWOT шинжилгээний үндсэн дээр давуу талуудаа бүрэн дүүрэн ашиглах, боломжоо давуу тал болгох, сул талаа давуу тал руу хөрвүүлэх учирч болох саад бэрхшээл, аюулыг арилгах даван туулах арга замыг олох зорилгоор тухай нөхцөл бүрд чиглэсэн маркетингийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх.

Зорилт 1 -Улс, аймаг орон нутгаас батлагдсан төсвийн хүрээнд тендерт шалгарсан гүйцэтгэгч компанитай уялдаа холбоотой ажиллаж гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ хийх

Зорилт 2 -Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг тааруулан бүтэц орон тоог нэмэгдүүлэх, ажилчдын тоог 70-д хүргэх, хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилчдыг мэргэшлийн болон холбогдох сургалтад хамруулах

Зорилт 3 -Бүтээгдэхүүн ажил үйлчилгээнээс авах ашгийг хэрэгцээндээ тулгуурлан хуваарилах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, ажилчдын цалин, хоолны хөнгөлөлт нэмэгдүүлэх байдлаар хяналттай зарцуулах

Зорилт 4 –“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Улаангом сумын хэмжээн дэх нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Компани/ОНТҮГ-ын гадаад, дотоод орчин

2006 онд Хот тохижилт, орон сууцны үйлчилгээний газар нэртэйгээр 23 хүний бүтэц, орон тоотойгоор байгуулагдсан байна. Увс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны А/25 дугаар тогтоолоор “Улаангом тохижилт үйлчилгээ” Орон нутгийн төсөвт үйлчилгээний газар болгон өөрчилж, удирдах 1, гүйцэтгэх 8, туслах 31 нийт 40 ажилтны бүтэц, орон тоотойгоор байгуулсан байна. 2024 оны 12 сарын 5-ны 14-р тогтоолоор Улаангом сумын Засаг даргын харьяанд шилжүүлэн удирдах 1, гүйцэтгэх 11, туслах 44 хүний бүтэц орон тоотойгоор шилжүүлсэн байна. 2025 оныхоо Бизнес төлөвлөгөөг 2025 оны 1-р сарын 15-ны дотор Сумын Засаг дарга баталсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3 дэх заалтад заасны дагуу байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж өмнөх оноос өөрчлөлт оруулаагүй баталсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 26,759,619.7 мянган төгрөг болж өмнөх оноос 21,133,213.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,584.5	41.1	-4,543.4
Авлага	211.8	12,657.0	12,445.2
Бараа материал	164,626.0	253,525.0	88,899.0
Үндсэн хөрөнгө	5,456,983.9	26,493,396.6	21,036,412.7
Нийт хөрөнгө	5,626,406.3	26,759,619.7	21,133,213.4

Өр төлбөр	729.4	38,328.8	37,599.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,625,676.9	26,721,290.9	21,094,614.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,626,406.3	26,759,619.7	21,133,213.4

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 41,1 мянган төгрөг болж 4,543.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 12,657.0 мянган төгрөг болж 12,445.2 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбогдсон авлага болон төлбөртэй үйлчилгээний авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 253,525.0 мянган төгрөг болж 88,899.0 мянган төгрөгөөр өссөн нь "Улаангом сумын зам дагуух ногоон байгууламжийн" тендерийн хүрээнд Улаангом сумын доторх нийтийн эзэмшлийн Ногоон байгууламжийн ажил хийж олон төрлийн гацуур болон бусад төрлийн мод орлогод авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй ба байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулахтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 26,493,396.6 мянган төгрөг болж 21,036,412.7 мянган төгрөгөөр өссөн нь Улаангом сумын Засаг даргын тамгын газраас Увс Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 сарын 02-ны 67 дугаар тогтоолоор балансаас баланст шилжигч ирсэн хөрөнгө болон Увс аймгийн 100 жилийн тэмдэглэлт ойтой холбоотойгоор нийтийн эзэмшлийн талбайд хийсэн бүтээн байгуулалтын ажлуудыг хүлээн авч бүртгэснээр өссөн байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 38,328.8 мянган төгрөг болж 37,599.4 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбогдсон өглөг болон байгууллагад төлөх тогтмол зардлын өглөг данс өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 26,721,290.9 мянган төгрөг болж 21,094,614.0 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн орлогоос голлон шалтгаалжээ.

2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 24,714,399.7 мянган төгрөг болж өмнөх оноос 22,568,999.7 мянган төгрөгөөр өссөн байгаа нь нийтийн эзэмшлийн зам талбайн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд нийт зардал нь өмнөх оны зардлаас 1,511,986.9 мянган төгрөгөөр буюу 71.8 хувиар өссөн байна. Энэ нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, цалингийн зардал, тээвэр шатахууны зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, Улаангом сумын засаг даргаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улаангом сумын Засаг дарга 2025 оны 01 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг 998,088.9 мянган төгрөгийн орлого, нийт 1,123,290.7 мянган төгрөгийн зардалтай, 125,201.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн дүнгээр алдагдалтай ажиллахаар төсвийн саналыг Улаангом сумын Засаг дарга баталсан байна.

Төлөвлөлтөд орон нутгийн төсвөөс 2,153,569.8 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 31,017.6 мянган үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 60,000.0 мянга, урьд оны үлдэгдлээс санхүүжих 4,584.5 мянга, нийт 2,249,171.9 мянган төгрөгийг санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулахаар тусгасан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,153,569.8 мянга, туслах үйл ажиллагаанаас 407,835.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 233,972.4 мянга нийт 2,795,378.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж урсгал үйл ажиллагааны нийт 2,800,121.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	440.0	440.0	Аcolous программ ашигладаг.
2	Унаа, хоолны зардал	109,800.0	97,837.3	Ажилтнуудад хоолны хөнгөлөлт 1 өдрийн 7.5 мянган төгрөгөөр тооцон олгож байна
3	Сургалт, семинар	0.0	0.0	Сургалт, семинарын зардал гараагүй байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	0.0	Гадаад томилолтын зардал байхгүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	ТӨҮГ-ын судалгаа	2,795,577.6	2,795,577.6	Тайлант онд хүүгийн орлого-199.5 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлого-641,808.3 мянга, урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 2,153,569.8 мянга, нийт 2,795,577.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.
7	Орон тооны цомхотгол	0.0	0.0	Орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
8	Хэвлэл, мэдээлэл	3,900.0	3,900.0	Тайлант онд сама-увс телевизтэй-1,500.0 мянга, МВС телевизтэй-2,400.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын хувьд 2025 онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 183,965.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “ Шатахуун шатах тослох материал нийлүүлэх” тендер зарлаж худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 82 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,618,405.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 36,184.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 28,947.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,618,301.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 36,183.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 28,946.4 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

“Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын захирлын 2025 оны А/04, А/30, А/39 дүгээр тушаалуудаар баруун бүсийн нөхөрсөг уулзалт, спортын уралдаан, тэмцээнүүдэд болон нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын ажилчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд төсвөөс 9,630.0 мянган төгрөгийг зарцуулсанд албан шаардлага өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ нь шилэн дансны цахим хуудаст төсөв, хөрөнгө зарцуулах 36,534.0 мянган төгрөгийн 16 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,158,857.9 мянган төгрөгийн 14 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 781,839.3 мянган төгрөгийн 53 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 3,220.0 мянган төгрөгийн 5 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн. Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд асуудлын бүртгэл хөтөлсөн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,003,339.1 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 12,766.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 491.2 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9,630.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгч, 1,980,451.2 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

1. Үр дүнгийн тайлангаар 12,766.7 мянган төгрөгийн ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн зардалд буруу бүртгэсэн байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.6 дахь “Бүх зардал” Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсанд залруулга хийлээ.

5.1 Төлбөрийн акт

“Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын менежер албан тушаалтай ажилтанд сахилгын шийтгэлтэй байх хугацааг оролцуулан тооцож 491.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Дээрх зөрчил нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 дахь хэсэгт “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, 123.9 дэх хэсэгт “Ажил олгогч энэ хуулийн 123.8-д заасан хугацаанаас өмнө ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцож болох бөгөөд энэ тухай ажилтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлтэй байх хугацаанд тооцож олгосон үр дүнгийн урамшууллын 491.2 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

“Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын захирлын 2025 оны А/04, А/30, А/39 дүгээр тушаалуудаар баруун бүсийн нөхөрсөг уулзалт, спортын уралдаан, тэмцээнүүдэд болон нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын ажилчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд төсвөөс 9,630.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”,

12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8 дахь заалтад “Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”, 15.2 дахь хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.7 дахь заалтад “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг мөрдөж ажиллах, төсвөөс хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй ажиллахыг албан шаардлага болгов.

5.3 Зөвлөмж

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ нь шилэн дансны цахим хуудаст төсөв, хөрөнгө зарцуулах 36,534.0 мянган төгрөгийн 16 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,158,857.9 мянган төгрөгийн 14 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 781,839.3 мянган төгрөгийн 53 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 3,220.0 мянган төгрөгийн 5 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд зардал буруу тайлагнасан.	1	12,766.7			1	12,766.7	1	12,766.7				
Дүн	1	12,766.7			1	12,766.7	1	12,766.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тэмцээн уралдаан, сургалтын зардал, тэмдэглэлт өдөрт	1	9,630.0			1	9,630.0						
Сахилгын шийтгэлтэй ажилтанд урамшуулал олгосон.	1	491.2	1	491.2								
Дүн	2	10,121.2	1	491.2	1	9,630.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст 16 мэдээлэл байршуулаагүй, 72 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.	1	1,980,451.2					1	1,980,451.2
Дүн	1	1,980,451.2					1	1,980,451.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАН



2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр